

ГАРЧИГ

НЭГ. 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа	5
1.3. Ил уурхайн ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт	6
1.4. Боловсруулалтын хэсэг.....	7
1.5. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц.....	8
1.6. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлт	10
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
ГУРАВ. УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	15
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ...	22
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	24
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
ДҮГНЭЛТ	30

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө	5
Хүснэгт 2. Уурхайн ажлын горим.....	5
Хүснэгт 3. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт	8
Хүснэгт 4. Цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалтын хэмжээ.....	9
Хүснэгт 5. Уурхайн нийт усны хэрэглээ.....	10

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байриил.....	4
Зураг 2. Уурхайн гол замыг засаж сайжруулсан байдал.....	12
Зураг 3. Дүйцүүлэн хамгаалах ажлын талаарх албан бичиг.....	13
Зураг 4. Уурхайн талбайд мод хучих шимт хөрсийг тусгайлан бэлтгэсэн байдал.....	14
Зураг 5. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ.....	15
Зураг 6. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ.....	16
Зураг 7. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ.....	17
Зураг 8. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ.....	18
Зураг 9. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлбөрийн баримт.....	18
Зураг 10. Аюулгүй хог хаягдлыг булах, зайлуулах үйлчилгээний гэрээ.....	19
Зураг 11. Аюулгүй хог хаягдлыг булах, зайлуулах үйлчилгээний гэрээ.....	20
Зураг 12. Хог хаягдлын гэрээний төлбөрийн баримт.....	21
Зураг 13. ХХАА-ны хувцас хэрэгсэл.....	22
Зураг 14. ХХАА-ны хувцас хэрэгсэл.....	22
Зураг 15. Нийгмийн хариуцлагын гэрээ.....	23
Зураг 16. Нийгмийн хариуцлагын гэрээ.....	24
Зураг 17. Нийгмийн хариуцлагын гэрээний төлбөрийн баримт.....	24
Зураг 18. ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэх тухай гэрээ.....	25
Зураг 19. ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэх тухай гэрээ.....	26
Зураг 20. Агаарын чанарын шинжилгээний үзүүлэлт.....	27
Зураг 21. Хөрсний шинжилгээний үр дүн.....	28
Зураг 22. Усны шинжилгээний үр дүн.....	29

НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Цахиуртын доломитжсон гантигийн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Мон кварц” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011030077, Регистрийн дугаар: 2824833, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV- 016912


Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил: “Мон кварц” ХХК-ийн эзэмшдэг MV- 016912 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Цахиуртын доломитжсон гантиг” нэртэй талбай нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт, Улаанбаатар хотоос 240 км, Дархан хотоос баруун урагш 20 км-г, 74.18 га талбайг эзлэн оршино.

Талбайн солбицлууд:

1.	49° 22' 16.91”	105° 49' 26.15”
2.	49° 22' 11.91”	105° 49' 26.15”
3.	49° 22' 11.91”	105° 50' 14.16”
4.	49° 21' 54.91”	105° 50' 14.16”
5.	49° 21' 54.91”	105° 49' 26.15”
6.	49° 22' 01.91”	105° 49' 26.15”
7.	49° 22' 01.91”	105° 49' 01.16”
8.	49° 22' 16.91”	105° 49' 01.16”

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:

Улсын бүртгэлийн гэрчилгээ
✓ Улсын бүртгэлийн дугаар: 9011030077
✓ Регистрийн дугаар: 2824833
✓ Улсад бүртгүүлсэн: 2006.07.19
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл
✓ Дугаар: MV-016912
✓ Олгосон огноо: 2011.08.29



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Уурхайн жилийн хүчин чадлыг үндэслэхдээ жилд хуулах хөрсний хэмжээ, хүдрийн биетийн тогтоцоос хамаарч, мөн захиалагч талын өгсөн техникийн даалгавар, зах зээлийн судалгаа, ажлын нөхцөл зэргийг үндэслэн эхний 2 жилд дунджаар 34.0 мян.тн, удаах жилүүдэд 60.0 мян.тн-оор нийт 33 жил гантиг олборлохоор тооцооллоо.

Ил уурхай нь үндсэн олборлолтын хүчин чадалд хүрэх зорилгоор хөрс хуулалт, хүдрийн биетийг нээх, техник, технологиудыг суурилуулах болон бусад бэлтгэл ажлуудыг шийдвэрлэх учир эхний 2 жилд төслийн хүчин чадлаар бүрэн ажиллаж чадахгүй юм. Иймд нийт ашиглалтын хугацаанд жигд гантиг олборлох ил уурхайгаар ашиглах ашиглалтын жилийг 33 жилээр тогтоон ТЭЗҮ-н тооцоонд тусгасан байна. Харин уурхайн хаалт болон нөхөн сэргээлт, нөхөн сэргээсэн талбайг хамгаалж, хадгалах зорилготой ажиллах хугацааг сүүлийн жилд байхаар төсөлд тооцлоо. Иймд уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд			
			1-2-р жил	3-10-р жил	11-33-р жил	Нийт
Нийт уурхайн хэмжээнд	Хөрс хуулалт	мян.м ³	10	18.3	12.8	460.5
	Гантиг олборлолт	мян.тн	33.87	60	60	1927.74
	Уулын цул	мян.м ³	22.54	40.5	35.02	1174.5
	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	0.3	0.3	0.2	0.24

Хүснэгт 2. Уурхайн ажлын горим

д/д	Нэрс	Хэмжих нэгж	Жилд
1	Жилийн ажлын өдөр	хоног	244
2	Амралт, баяр ёслол	хоног	3
3	Цаг агаарын хүндрэл	хоног	8
4	Урсгал засвар хийгдэх	хоног	8
5	Уурхайн ажиллах ажлын өдөр	хоног	225
6	Уурхайн бэлтгэл ажил	хоног	5
7	Хөрс хуулах боломжит хоног	хоног	220
8	Олборлолт явуулах боломжит хоног	хоног	215
9	Нэг хоног дахь ээлжийн тоо	ээлж	2
10	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

1.3. Ил уурхайн ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт

1.3.1. Ашиглалтын систем

Цахиуртын доломитжсон гантигийн уурхайн уул-техникийн нөхцөл, хүдрийн биетийн тогтоц, жилд хийгдэх нийт уулын цулын хэмжээ зэргээс хамаарч хөрс хуулалт, болон олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ – экскавациалт – автосамосвал – гадаад овоолго гэсэн ил уурхайн автотээвэртэй ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

Уурхайн автозамыг байгуулахдаа олборлолтын ажлын талбайгаас гантигийн түр овоолго хүртэлх, хөрсний чулуулгийг гадаад овоолго хүртэл тээвэрлэх зай нь хамгийн бага байхаар тооцож байгуулсан.

Уурхайн хөрс нь аргиллит, элсэн чулуу зэрэг голдуу дунд зэрэг бөх чулуулгууд байх бөгөөд урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийсний дараа экскаватороор хутган автосамосвалд ачиж ил уурхайн гадаад овоолгод, ашигт малтмалыг гантигийн түр овоолгод тээвэрлэн байршуулна.

1.3.2. Ил уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

Өрөмдлөг тэсэлгээний ажил

Ордын хөрсний чулуулгийн хатуулгийн коэффициент нь профессор М.М.Протодьяконовын ангилалаар $f=3-7$ байна. Иймээс уулын ажлыг жигд найдвартай явуулах үүднээс хөрсөнд өрөмдлөг тэсэлгээний ажил хийх шаардлагатай.

Уурхайд хамгийн их ачаалалтай ажиллах жилд KQG100 маркийн өрмийн машин хөрс болон хүдэрт ажиллахад нийт 1 ш байхад хүчин чадал уурхайн хэмжээнд хүрэлцээтэй байна. Иймээс сэлбэгийн олдоц их, техникийн маневэрлах чадвар сайн, мөн цахилгаан эрчим хүчээр хангагдах зэрэг үзүүлэлтээс хамааран БНХАУ-д үйлдвэрлэсэн KQG100 маркийн өрмийн машин 1 ш байхаар төсөлд сонгон авлаа.

Экскаваторын бүтээл болон хэрэгцээний тооцоо.

Уурхайд ажиллах экскаваторыг сонгохдоо манай оронд өргөн хэрэглэгддэг, сэлбэг хэрэгслийн олдоц сайтай, үнэ хямд түлш бага зарцуулдаг зэрэг үзүүлэлт болон компаниас санал болгосны дагуу Komatsu PC210 маркийн экскаватор сонголоо.

Уурхай нь хөрс хуулалт болон гантиг олборлолтонд эхний 2 жилд 22.54 мян.м³, 3-10 дахь жилд 40.5 мян.м³, 11-33 дахь жилд 35.02 мян.м³ уулын ажил хийх бөгөөд тооцоонд сонгосон Komatsu PC210 маркийн экскаватор жил бүр 1 ш байхад хүчин чадал хүрч байна.

Дотоод тээврийн автосамосвалын бүтээл болон хэрэгцээний тооцоо

Уурхайн хөрс, гантиг тээвэрлэх ажилд 10.6 м³-ийн тэвшний багтаамжтай БНХАУ-д үйлдвэрлэсэн HOWO маркийн автосамосвалуудыг ажиллуулахаар төлөвлөв. Иймд дээрх автосамосвалын бүтээлийн тооцоог автосамосвалын техникийн үзүүлэлтүүдэд тулгуурлан доорх байдлаар тодорхойлсон. Ил уурхайн хөрс тээвэрлэх дундаж зай 0.4 км, гантиг тээвэрлэх дундаж зай 0.6 км тус тус байна.

Ил уурхайн жилд хийгдэх нийт уулын цулын хэмжээгээр тооцоход 25 тн-н HOWO маркийн автосамосвал 1 ш байхад хүчин чадал хүрч байгаа боловч экскаваторыг тээврээр хангах

нөхцөл мөн техникийн бэлэн байдлын нөхцөлийг тооцон жилд 2 ш автосамосвал ажиллахаар тооцлоо.

Утгуурт ачигчийн бүтээл болон хэрэгцээний тооцоо

Уурхайгаас тээвэрлэгдэн ирсэн гантигийг түр овоолгод байршуулах бөгөөд тус хэсгээс гадаад тээврийн автосамосвалуудад гантигийг ачих ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн LG953 маркийн 3.0 м³ шанаганы багтаамж бүхий утгуурт ачигчийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.

Бульдозерийн бүтээл болон хэрэгцээний тооцоо

Уржил шимт хөрс буюу өнгөн хэсгийн хөрсийг SD-16 маркийн бульдозероор карьерийн гадна тал руу түрж овоолго үүсгэнэ. Энэхүү шимт хөрсийг уурхайн техникийн нөхөн сэргээлт хийсэн хэсэгт тарааж тэгшлэн мод, бут тарих болон олон наст ургамлын үр цацах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах болно.

Уурхайгаас тээвэрлэгдэн ирсэн хөрсийг уурхайн гадаад овоолгод асгах ба бульдозерийн тусламжтайгаар түрж тэгшлэх ажлыг гүйцэтгэнэ.

Үүнээс гадна хаягдал багатай олборлох үүднээс олборлож буй талбайн улыг бульдозероор түрж бөөгнүүлэн экскаваторт бэлтгэж өгөх, уурхайн технологийн зам талбай засах болон туслах тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн зөөх зэрэг уурхайн бусад туслах ажилд хэрэглэнэ.

Гадаад тээврийн автосамосвалын бүтээл болон хэрэгцээний тооцоо

“Мон кварц” ХХК-н баяжуулах үйлдвэр ашиглалтын талбайгаас 20 орчим км-н зайд байрлах бөгөөд гантиг тээвэрлэх ажилд 25 тн-н даацтай БНХАУ-д үйлдвэрлэгдсэн HOWO төрлийн автосамосвалаар гүйцэтгэхээр сонгож авав. Уурхайн гадаад тээвэрт сонгосон 25 тн-н даацтай HOWO маркийн автосамосвал эхний 2 жилд 2 ш удаах жилүүдэд 3 ш байхад хүчин чадал хүрэхээр байна.

1.4.Боловсруулалтын хэсэг

1.4.1. Боловсруулах үйлдвэрийн тодорхойлолт

Боловсруулах үйлдвэр нь уурхайгаас 20 орчим км, Дархан хотын төвөөс 6 км, төмөр замаас дунджаар 1 км-ын зайд байрладаг. Жилийн хүчин чадал 30-60 мян.тн боловсруулах чадалтай. Боловсруулах технологи нь ангилан нунтаглалтын аргаар явагдах ба ус ашиглахгүй. Боловсруулах тоног төхөөрөмжүүд нь вакумжсан ба нунтаг тоосыг өөрөө шүүх сэнстэй тоосжилт гарахгүй.

Боловсруулах үйлдвэрийн ажиллах хугацаа, хүчин чадал

Үйлдвэрийн ажлын горимыг дараах байдлаар тусгалаа.

- ✓ Жилд ажиллах хоног – 215
- ✓ Хоногт ажиллах ээлж – 1
- ✓ Ээлжийн үргэлжлэх хугацаа /цаг/ – 10
- ✓ Жилийн хүчин чадал – 30-60 мян.тн
- ✓ Ээлжийн хүчин чадал –139.5-279 тн
- ✓ Цагийн хүчин чадал –14-28 тн

1.4.2. Ангилан ялгах тоног төхөөрөмжийн технологийн схем

Эрдэс нунтгийг үйлдвэрлэхийн тулд үндсэн хоёр хэсгээс бүрддэг. Хүдрийг бэлтгэх, нунтаглах үйл ажиллагаа ордог.

Уурхайгаас автосамосвалаар доломитыг тээвэрлэж, тусгай зассан талбай (1 сарын үйлдвэрлэлийн нөөцийн овоолго багтах)-д овоолго үүсгэн буулгах ба овоолгоос доломитыг авто ачигчаар хүлээн авах бункер хийх бөгөөд бункерийн доор байрлах доргиурт тэжээгүүр хацарт бутлуурыг тэжээнэ.

Хүлээн авах бункер дээр тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 35-45° налуутай төмөр замын рельс төмрөөр хийсэн хоорондоо 300 мм-ийн зайтай хяналтын шигшүүрийг байрлуулна.

Доргиурт тэжээгүүрээр -300+0 мм-ийн ширхэглэлтэй доломитыг хацарт бутлуурт тэжээгдэх бөгөөд хацарт бутлаараас -65+0 мм-ийн ширхэглэлтэй доломит конусан бутлуурт орж бутлагдан -30+0 мм-ийн ширхэглэлтэй болж туузан зөөгүүр дамжин чичиргээт шигшүүрт хүргэгдэнэ. Чичиргээт шигшүүрээс +30 мм, -30+10 мм, -10+5 мм, -5+0 мм ширхэглэлтэй дөрвөн төрлийн бүтээгдэхүүн гарна.

Хүснэгт 3. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт

Д/д	Тоног төхөөрөмж	Марк	Тоо ш	Хүчин чадал (тн/цаг)	Цахилгаан хөдөлгүүрийн чадал (кВт/цаг)
1	Тэжээгүүр	GZD850x3000	1	80-120	7.5
2	Хацарт бутлуур	PE400x600	1	25-65	30
3	Конусан бутлуур	PYB600	1	40	30
4	Шигшүүр	ЗҮК1848	1	32-276	18.5
5	Туузан зөөгүүр	B500	5	40-80	5.5
6	Туузан зөөгүүр	B650	2	80-120	7.5
7	Тээрэм	MTM100	1	21 ~ 34	
8	Бункер	V=50м³	1	-	

1.5. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.5.1. Уурхайн барилга байгууламж

Уурхайн бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалт

Ил аргаар гантиг олборлох “Цахиуртын доломитжсон гантигийн уурхайд үйлдвэрийн үндсэн болон туслах бага оврын объектуудыг барьж байгуулах шаардлагатай бөгөөд тэнд ажиллах ажиллагсдын хөдөлмөрлөх нөхцөлийг сайн хангах хэрэгтэй.

Уурхайн бүрэлдэхүүнд:

- ✓ Хөрс хуулах, гантиг олборлох ил уурхай, хөрсний овоолго
- ✓ Захиргаа, үйлчилгээний байрууд
- ✓ Цахилгаан хангамж / цахилгаан станц /
- ✓ Ажилчдын байр
- ✓ Засварын газар
- ✓ Хоолны газар
- ✓ Уурхай орчмын замууд (уурхайн эзэмшлийн талбайн хүрээнд орших) зэрэг объектууд багтана.

Төсөлд эдгээр аж ахуй, үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг чингэлэгүүд болон сендвичэн хавтан ашиглан өөрсдийн хүчээр барьж байгуулах ба холбогдон гарах зардлыг хөрөнгө оруулалтын зардалд шингээсэн болно.

Захиргаа үйлчилгээний газар, ажилчдын сууц

Захиргаа үйлчилгээний объектуудад уурхайн удирдлагуудын контор (ажлын өрөө), наряд – даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох байр зэрэг газрууд орно. Эдгээр объектуудыг сендвичэн хавтан ашиглан өөрсдийн хүчээр барьж байгуулах ба энэ зардлыг уурхайн хөрөнгө оруулалтын зардалд тусгаж өгсөн болно.

Уурхайн засвар техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй

Гантиг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд шаардлагатай техник тоног төхөөрөмж, цахилгаан багаж төхөөрөмж зэргийг засварлах, хэвийн ажиллагааг хангах зорилгоор засварын газар байгуулна. Засварын газрыг дараах төхөөрөмжүүдээр тоноглоно. Үүнд:

- ✓ Токарь, өрмийн цахилгаан машин
- ✓ Өргөх төхөөрөмж, слесарийн бусад багажууд
- ✓ Гагнуурын зориулалтын талбай бусад багажууд
- ✓ Бусад хэрэглэгдэх багаж хэрэгслүүд

Эдгээр төхөөрөмжүүдийг вагончикт байрлуулах боломжтой бөгөөд дэргэд нь автомашин, бульдозер, утгуурт ачигч зэргийн засвар хийх боломжтой зориулалтын зарим тоног төхөөрөмжөөр тоноглогосон задгай талбай барьж байгуулна. Эдгээрийн нийт зардлыг тооцоолон хөрөнгө оруулалтын зардалд тусгасан болно.

Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түр агуулахад 20 тн-ын багтаамжтай контейнер ашиглана.

1.5.2. Цахилгаан хангамж

Цахиуртын доломитжсон гантигийн ордын цахилгааны гол хэрэглэгчид нь өрмийн машин, засварын цех, уурхайн тосгон, зумфны насос болон бусад жижиг хэрэглэгчид байна.

Ордоос 4 км зайд төвийн эрчим хүч явж байгаа бөгөөд уг төвлөрсөн эх үүсвэрээс уурхайн цахилгаан хэрэглэгчидийг эрчим хүчээр хангахаар тооцлоо.

Ил уурхайн уулын ажил явагдах нийт ажлын талбай, үйлдвэр, цехийн байр, ажиллаж байгаа машин техникийн ойр орчим, ажилчдын байнга явах зам зэрэг талбайг харанхуй үед зайлшгүй гэрэлтүүлэх шаардлагатай.

Хүснэгт 4. Цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалтын хэмжээ

№	Тоног төхөөрөмж, материалын нэр	Хэмж нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ, сая.төг	Бүгд үнэ сая.төг
1	А-70 маркийн утастай 10 кВ-н агаарын шугам	км	4	15	60
2	КТП-100 төрлийн 10/0.4 кВ-н трансформаторын иж бүрэн дэд станц	ш	1	15	15
3	КТП-40 төрлийн 10/0.4 кВ-н трансформаторын иж бүрэн дэд станц	ш	1	8	8
4	0.4 кВ-ын кабель шугам	км	1	35	35
5	0.4 кВ-ын агаарын шугам	км	0.5	7	3.5
	Дүн				121.5
6	Бусад		5%		6.1
	Бүгд				127.6

1.5.3. Усан хангамж

Уурхайн усны хэрэгцээ нь үндсэндээ ахуйн хэрэглээний усны хэрэгцээгээр тодорхойлогдоно. Уг хэрэгцээний усыг ойролцоох гүний худгаас зөөврөөр хангахаар төлөвлөсөн болно.

Уурхайд нийт 26 хүн ажиллах ба нэг хүний хэрэгцээний усыг хоногийн 150 л, уурхайн зам талбай услах ажилд нэг ээлжинд 5 тн ус хэрэглэнэ гэж үзээд тооцлоо. Унд ахуйн хэрэгцээнд нийт $26 \times 150 \times 225 = 877\,500$ л буюу жилд 877.5 м^3 ус зарцуулахаар байна.

Зам талбайн усалгаанд нэг удаадаа 5.0 м^3 ус хэрэглэх ба жилд дунджаар 90 өдөр усалгаа хийхэд нийт 450.0 м^3 ус зарцуулна.

Хүснэгт 5. Уурхайн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлт	Жилд, м^3
1	Ахуйн хэрэгцээний усны хэмжээ, м^3	877.5
2	Технологийн зам талбай услах усны хэмжээ, м^3	450
3	Нийт цэвэр ус зарцуулалт, м^3	1327.5

1.6. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлт

2025 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 31.01 мян.тн гантиг олборлон борлуулахаар төлөвлөсөн боловч 2025 оны 10-р сарын байдлаар 10.0 мян.тн гантиг олборлосон байна.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг хийлгэсэн.
3	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Ус ашиглах гэрээ байгуулж, усны төлбөрийг төлсөн.
4		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх	
5		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Усны шинжилгээ хийлгэсэн.
6	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	
7	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
8	Гантиг олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ	Уурхайн олборлолтыг батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж, аваар осолгүй ажилласан.
9	Уурхайгаас олборлосон гантигийг бутлах, ангилах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
10	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.



Зураг 2. Уурхайн гол замыг засаж сайжруулсан байдал

ГУРАВ. УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд мод тарихаар төлөвлөсөн бөгөөд тус ажлыг хийж гүйцэтгэсэн болно.



Зураг 3. Дүйцүүлэн хамгаалах ажлын талаарх албан бичиг

Уурхайн талбайд 2022-2024 онуудад мод тарьсан боловч хөрсний үржил шимээс шалтгаалан сайн ургаагүй тул 2025 онд үржил шимт хар шороон хөрсийг тусгайлан бэлтгэсэн болно.



Зураг 4. Уурхайн талбайд мод хучих шимт хөрсийг тусгайлан бэлтгэсэн байдал

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Мон кварц” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайд галын булан байрлуулсан бөгөөд өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, тэсрэх материалын сав баглаа боодлыг сервис компанид хүлээлгэн өгч аюул осолгүй ажилласан болно.



Энэхүү гэрээг Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр заалтуудыг үндэслэн: Нэг талаас Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 11-р хороо, Зүүн ард Аюуш, 1-21 тоот Улсын бүртгэлийн № 9011030077, РД-2824833 тоот дугаартай “Монкварц” ХХК түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Мягмарсүрэн цаашид “Захиалагч” гэх,

Нөгөө талаас Сүхбаатар дүүрэг 11-р хороо, Pro One оффис 8 давхар 804 тоотод байрлах Улсын бүртгэлийн № 901105119, РД-5147816 тоот дугаартай “Ти Эм Би Эн” ХХК, түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал албан тушаалтай Д.Бат-Очир цаашид “Гүйцэтгэгч” гэх, гэрээнд оролцогчдыг хамтад нь “талууд” гэх, харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээний зорилт нь Гүйцэтгэгч тал нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах Цахиуртын ордын өрөмдлөг, тэсэлгээний ажил үйлчилгээг цаашид тэсэлгээний ажил гүйцэтгэх гэх\ гүйцэтгэх, захиалагч тал ажил, үйлчилгээний төлбөр төлөхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Байршил: Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах Цахиуртын орл.
- 1.3. Энэхүү гэрээ нь хоёр талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 1.4. Дор дурьдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
 - Тусгай зөвшөөрлийн хуулбар
 - Компанийн гэрчилгээний хуулбар
 - Холбогдох бусад баримт бичиг
- 1.5. Гэрээний хугацаа: Энэхүү гэрээний хугацаа нь гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл байна.
- 1.6. Ажлын хэмжээ: 10 000 м³

ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Тэсэлгээний ажлын төлбөр: – Өрөмдлөг, тэсэлгээний ажил 1м³ нь 6000 (зургаан мянга) төгрөг НӨАТ орсон болно.
- 2.2. Өрөмдлөгийн төлбөрийг ажил эхлэхийн өмнө 60 хувь, өрөмдлөгийн ажил хийгдэж дууссаны дараагаар үлдэгдэл 40 хувийн төлбөрийг Гүйцэтгэгчийн Хас банкны IBAN 32003200 5002780549 тоот дансанд төлбөрийг шилжүүлнэ.
- 2.3. Ажил гүйцэтгэх явцад ажлын хэмжээ нэмэгдсэн тохиолдолд гэрээнд заасны дагуу

Зураг 5. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ

Тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ 2025 он

төлбөрийг барагдуулна.

- 2.4. Хэрэв гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох шаардлага, дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгээгүй бол Захиалагч тус ажлын төлбөрийг төлөх үүрэг хүлээхгүй.
- 2.5. Гүйцэтгэгчийн буруугаас үүдэн аливаа нэмэлт зардал /дутуу тэсэлгээ хийсэн доголдлыг арилгуулах, гэрээт ажлыг гүйцээн хийлгэхтэй холбоотой зардал, талууд тоо хэмжээн дээр маргаан гаргасан тохиолдолд гуравдагч этгээдээр тогтоолгох/-ыг гэрээний төлбөрөөс суутгана.

ГУРАВ. АЖЛЫН ҮР ДҮНГ ХҮЛЭЭЛЦЭХ, БАТАЛГААТ ХУГАЦАА

- 3.1. Талууд тухайн блокын тэсэлгээний ажлыг хийж гүйцэтгэсний дараагаар актаар баталгаажуулан хүлээн авна.
- 3.2. Гэрээт ажлын эцсийн үр дүнг талууд хамтран нарийвчлан шалгаж холбогдох хууль, журам шаардлагад бүрэн нийцсэн гэж үзсэн тохиолдолд хүлээлцэх бөгөөд Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн тайланг бэлдэж, холбогдох баримт бичгийн хамт Захиалагчид хүлээлгэж өгнө.
- 3.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн болон холбогдох хууль, дүрэм, журам шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэсэн нь эрх бүхий байгууллагын дүгнэлт болон бусад байдлаар илэрсэн бол Гүйцэтгэгч нь тухайн доголдлыг арилгах арга хэмжээ авна.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ НӨХЦӨЛ

- 4.1. Захиалагчийн эрх үүрэг
- 4.1.1. Тэсэлгээний ажлын талаар шаардлагатай мэдээ, баримтыг авах эрхтэй.
- 4.1.2. Тэсэлгээний ажлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гүйцэтгэхэд шаардлага тавих эрхтэй.
- 4.1.3. Гүйцэтгэгчийн чанар стандартын шаардлагын дагуу гүйцэтгэсэн ажлыг гэрээний дагуу хүлээн авах эрхтэй.
- 4.1.4. “Монкварц” ХХК нь тэсэлгээний ажлыг гүйцэтгүүлэхдээ “Ти Эм Би Эн” ХХК нь өрөмдсөн цооногт тэсэлгээний бодисыг байрлуулах явцад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд сетик болон тэсэлгээний бодист санал өгөх эрхтэй.
- 4.1.5. Захиалагч нь батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу тэсэлгээний ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй.
- 4.1.6. Гэрээний дагуу төлбөрийг төлөх үүрэгтэй. Төлбөрийг заасан хугацаанд төлөөгүй хоног тутамд 0,5 хувийн алдангийг тооцож төлнө.
- 4.1.7. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажил эхлэхээс өмнө захиалагч талд мэдэгдэж, захиалагч нь тэсэлгээний аюулгүй бүсэд байгаа ажиглан, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг аюултай бүсээс гаргаж талбайг чөлөөлөх үүрэгтэй.
- 4.1.8. Хариуцсан албан тушаалтан томилж тэсэлгээний цооног, эгнээ хоорондын зайг тооцож тэслэгдэх талбайд тавьж, урьдчилсан байдлаар куб.м-ийн хэмжээг тооцож, өрөмдлөгийн паспорт акт гаргана.
- 4.1.9. Өрөмдлөгийн ажил дуусмагц хариуцсан албан тушаалтан томилж тэслэгдэх цооногт хэмжилт хийж куб.м-ийн хэмжээг эцсийн байдлаар тооцож акт үйлдэнэ.
- 4.1.10. Гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг төлнө.
- 4.1.11. Захиалагч нь тэсэлгээний ажлыг гуравдагч этгээдээр хийлгэхгүй байх үүрэгтэй.
- 4.1.12. Захиалагч нь ажил хийгдэхээс өмнө гүйцэтгэгчийн тэсэлгээний ажлын

Зураг 6. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ

Тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ 2025 он

паспорттай танилцаж, гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

4.1.13. Өрөмдлөг тэсэлгээ хийх үед ажилчдыг байр хоолоор хангана.

4.1.14. Өрөмдлөгийн тээврийн зардлыг захиалагч тал хариуцна.

4.1.15. Гүйцэтгэгчийг түлш тос тослох материалаар хангаж, зардлыг ажил үйлчилгээний үлдэгдэл төлбөрөөс хасна.

4.1.16. Захиалагч нь өрөмдлөг тэсэлгээний ажил явуулах нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

4.1.17. Ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардал /ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс гэх мэт/-ыг хариуцах үүрэгтэй.

4.1.18.

4.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.2.1. Захиалагч талаас төлбөрийг гэрээний дагуу төлөхийг шаардах эрхтэй.

4.2.2. Тэсэлгээний ажлын дараа баарсан цэнэг илэрвэл ажлыг зогсоож аюулгүй болгох арга хэмжээг тэсэлгээний ажлын удирдагчийн хяналтан дор явуулах үүрэгтэй.

4.2.3. Гүйцэтгэгч нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр тэсэлгээ хийх үүрэгтэй.

4.2.4. Гүйцэтгэгч нь холбогдох тусгай зөвшөөрөл болон бусад бичиг баримтыг бүрдүүлж, өрөмдлөг тэсэлгээний ажлын ажиллах хүчнийг 100% хариуцан гүйцэтгэх үүрэгтэй.

4.2.5. Гүйцэтгэгч нь захиалагч тал нь Тэсрэх материал ашиглах хяналтын хуудсаар тэсэлгээний ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.

4.2.6. Өрөмдлөгийн ажил дуусмагц хариуцсан албан тушаалтан томиж тэслэгдэх цооногт хэмжилт хийж куб.м-ийн хэмжээ болон орох тэсрэх бодисын хэмжээг эцсийн байдлаар тооцож акт үйлдэх үүрэгтэй.

4.2.7. Гүйцэтгэгч нь ажил эхлэхээс өмнө өрөмдлөгийн байршлыг тогтоож, тэсэлгээний ажлын төлөвлөгөө боловсруулж, захиалагч талын удирдах албан тушаалтнаар батлуулсны үндсэн дээр тэсэлгээний ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.

4.2.8. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажил явагдах хугацаанд аюулгүй байдлыг хариуцна. Тэсэлгээний ажил болон үе шат болгоны аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах, захиалагч талын төлөөлөгч болон өөрийн ажилчдад ХАБЭА-н зааварчилгааг өгөх бөгөөд захиалагч талаас зөвхөн талбайн зааварчилгаа өгч, үүнээс үүдэн гарах аливаа зүйлд хариуцлага хүлээхгүй болно.

4.2.9. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд өөрийн ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хариуцаж ажилчдын сахилга бат, дэг журам, зохион байгуулалтыг ханган ажиллах ба өөрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (ажлын хувцас, каск, гутал, бээлий г.м)-ээр тогтмол бүрэн хангаж ажиллуулах, дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актыг удирдлага болгон ажиллах үүрэгтэй.

4.2.10. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад өөрийн буруугаас бусдад эрүүл мэнд, амь нас болон эд материалын хохирол учруулсан тохиолдолд учруулсан хэмжээгээр хохирлыг бүрэн арилгах үүрэгтэй.

4.2.11. Гүйцэтгэгч нь уурхайд тэсэлгээний ажил гүйцэтгэх байршил, цаг хугацааг

Зураг 7. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ

Тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ 2025 он

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч талыг төлөөлж:	Гүйцэтгэгч талыг төлөөлж:
Менежер:	Тэсэлгээний менежер:
Утас:	Утас: 94701010
Ерөнхий нягтлан бодогч:	Ерөнхий нягтлан бодогч:
Утас: 99118557	Утас: 96068806
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 11-р хороо, Зүүн ард Аюуш, 1-21 тоот	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Про Ван оффис, 8 давхар, 804 тоот.
Утас:	Утас: 77224777, 99082734, 99119473
Цахим хаяг:	Цахим хаяг: imb@blasting.mn

Зураг 8. Өрөмдлөг тэсэлгээний ажил үйлчилгээний гэрээ

Нэхэмжлэгч

Төлөгч:

Байгууллагын	ТН ЭМ БН ЭН ХХК	Байгууллагын нэр:	* Монхварц * ХХК			
НӨАТ төлөгчийн дугаар:	5147816	НӨАТ төлөгчийн дугаар:	2824833			
Хаяг:	Сүхбаатар дүүрэг 11р хороо Про Ван 804 тоот	Хаяг:				
Утас, факс:	90987858					
Электрон шуудан		Гэрээний дугаар:	25/22			
Баланы нэр:	ХАС	Нэхэмжлэсэн огноо:	12/8/2025			
Баланы дансны	5002780549	Төдбөр хийх	12/8/2025			
№	Код	Баримт, ажил үйлчилгээ	Нэгж	Тоо	Үнэ	Нийт үнэ
1		Тэсэлгээний ажил үйлчилгээний урьдчилгаа 60 хувь	1м куб	10,000	6,000	36,000,000
(үсгээр)			НӨАТ-тэй дүн			36,000,000
Гучин зургаан сая төгрөг			НӨАТ			
			Нийт дүн:			36,000,000

(Тамга) Гүйцэтгэх захирагч: Бат-Очир / Д. Бат-Очир /
Нягтлан бодогч: / М.Номинтуяа /

Зураг 9. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлбөрийн баримт

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлыг түр хадгалах цэгийг ангилан ялгах боломжтой байдлаар тохижуулсан бөгөөд “Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ”-г байгуулан хуваарийн дагуу тогтмол тээвэрлүүлсэн болно.

Батланг: "Хог хаягдлын газар"-ын
Дарга: /С.Энхбаяр/

Батланг: /С.Энхбаяр/

Аюулгүй хог хаягдлыг булах, зайлуулах үйлчилгээний гэрээ №

2025 он 01 сар 25 өдөр

Сайхан сум

Нэг. Зорилго

Хотол хотыг цэвэр байлгаж хүмүүсийн амьдрах эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинг бүрдүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь орчин тойрныхоо газрын хог хаягдлыг байнга цэвэрлэн байгаль орчин экологийн тэнцвэртэй байдлыг хангаж хог хаягдлыг тогтоосон цэгт зайлуулах ба олон нийтийг хамарсан ажилд оролцон ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахад энэхүү гэрээний зорилго оршино. Энэхүү гэрээг нэг талаас “Хог тохижилтын газар /цаашид үйлчилэгч гэх/-ыг төлөөлж Орлогын байцаагч ажилтай С.Заяахүү ба нөгөө талаас /цаашид үйлчилүүлэгч гэх. захираа ажилтай Т.Нэгмурсурт нар харилцан тохирч 2025 оны 01...-р сарын 01...-нээс 2025 оны 12...-р сарын 31...-нийг хүртэл нэг жилийн хугацаатай гэрээг байгуулав.

Хоёр. Үйлчилгээний эрх, үүрэг

- 2.1 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, үйл ажиллагааг бүртгэлжүүлэх.
- 2.2 Хог хаягдлыг тээвэрлэх, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.3 Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ахуйн хог хаягдлыг тогтоосон хуваарийн дагуу цуглуулж, тээвэрлэх үүргийг хүлээнэ. /Жич: сард 1-2 удаа/
- 2.4 Хог хаягдлыг аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэн булах, хог хаягдлын цэгийн асуудлыг хянан ажиллана.
- 2.5 Их хэмжээний болон барилга байгууламжийн хог хаягдлыг захиалга авч төлбөр тооцоо хийгдсэний дараа буюу гэрээнд заасны дагуу ачиж тээвэрлэнэ. Дуудлагыг 95810290 /Нөгөөн байгууламж ТҮХМэргэжилтэн/ утсаар ажлын өдрийн цагаар “НЭГ” хоногийн өмнө хүлээж авна.

Гурав. Үйлчилүүлэгчийн эрх, үүрэг

- 3.1 Үйлчилүүлэгч нь хог хаягдлын үйлчилгээний ажлын талаар шаардлага болон санал хүсэлтээ тавих эрхтэй.
- 3.2 Үйлчилүүлэгч нь МУ-ын хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3, 10.2.4, 10.2.5-д заасны дагуу тээвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ хийсэний үндсэн дээр хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, тээвэрлүүлэхээр хүлээлгэн өгөх үүрэгтэй.

Зураг 10. Аюулгүй хог хаягдлыг булах, зайлуулах үйлчилгээний гэрээ

3.3 Өөрийн эзэмшиж байгаа орчны 50 метр хүртэлх эдэлбэр газрын талбайг цэвэрлэн хог хаягдлыг зориулалтын уут, шуудайнд хийж хог тээврийн машинд ачуулж байх.

3.4 10.2.11 заалтын дагуу барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах

3.5 Хог хаягдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.7, 24.10, 24.11-т заасныг тус тус мөрдөнө.

3.6 Мөн хуулийн 10.3.3-т заасны дагуу хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно.

3.7 Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрийг нийт дүнгээр улираллын эцсээр буюу 25-ны дотор төлж барагдуулах үүргийг хүлээнэ.

Дөрөв. Төлбөр тооцооны хэсэг

4.1 Хог хаягдлын үнэ тарифийг Монгол Улсын Хууль Зүй, Дотоод Хэргийн Сайдан 2023 оны 07 сарын 21-ны өдрийн 1/3960 тоот тогтоолыг үндэслэн Сумын ИТХ-ын 2022 оны 12-р сарын 20-ны өдрийн 53 тоот тогтоолоор батлуулсан ажиллаж байна.

4.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийг Төрийн сангийн 100130900947 /Сэ.Са Хог хаягдлын хураамж/, Хаан банк 5048334545 /Сэ.Сайхан Хот тохижуулах газар/ тоот дансанд сар бүрийн 25-ны дотор 30.000 төгрөгийг төлнө.

4.3 Хог хаягдлын үүсгэврийн хураамжийн хэмжээг зохих хууль тогтоомжийн дагуу өөрчлөгдсөн тохиолдолд иргэд, ААН байгууллагад мэдэгдэж мөрдөнө.

Гэрээний сунгалтын хугацааг хоёр тал ямар нэг санал тавиагүй бол харилцан сунгаснаар тооцно.

ГЭРЭЭ ХИЙСЭН

“Хот тохижилтын газар”-ыг төлөөлж
Орлогын байцаагч

А.Омговсзүр

Утас: 95728228

“Хот тохижилтын газар”-ыг төлөөлж:

Г.Мянгор

Утас: 95728228

Зураг 11. Аюулгүй хог хаягдлыг булах, зайлуулах үйлчилгээний гэрээ

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000003748634000251015000001906237
Борлуулагчийн:
ТТД: 3748634
НЭР: Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хот тохижилтын газар
Хаяг: Монгол, Сэлэнгэ, Сайхан, 1-р баг, Хөтөл, , 16,17 тоот
Утас: undefined
Банкны нэр: ХААН банк
Банкны дансны дугаар: 5048334545
Банкны IBAN дугаар: MN810005005048334545

Огноо: 2025-10-15
Худалдан авагчийн:
ТТД: 2824833
Нэр: Монкварц
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 11-р хороо, 1, 21 тоот
Утас:

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Аюулгүй хог хаягдлыг булах зайлуулах бусад төрлийн үйлчилгээ	9433200	ш	1	300,000	300,000
Бараа, ажил үйлчилгээний үнэ:						300,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						0
Нийслэл хотын албан татвар:						0
Нийт дүн:						300,000



Зураг 12. Хог хаягдлын гэрээний төлбөрийн баримт

ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан. Түүнчлэн ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан болно.



Зураг 13. ХХАА-ны хувцас хэрэгсэл



Зураг 14. ХХАА-ны хувцас хэрэгсэл

САЙХАН СУМЫН ЗДТГ, УУЛ УУРХАЙН ААНБ-ЫН ХООРОНД БАЙГУУЛСАН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2025.04.08

Сайхан сум

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг үндэслэн энэхүү гэрээг.

Нэг талаас Сэлэнгэ аймаг Сайхан сумын “Засаг даргын Тамгын газар” гэх /төлөөлж Сайхан сумын Засаг дарга бөгөөд Хөтөл хотын захирагч Б.Мөнхтөр, нөгөө талаас “Монкварц” ХХК-ийг төлөөлж Захирал Г.Мягмарсүрэн нар нь Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.13, 59.1.5 дах заалтуудыг тус тус үндэслэн дор дурьдсан нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож энэхүү Нийгмийн хариуцлагын гэрээ /цаашид гэрээ гэх/-г байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ, ЗДТГ-ын хоорондын хамтын ажиллагааг сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх тогтвортой бичил уурхайг хөгжүүлэхэд оршино.

ХОЁР. УУЛ УУРХАЙН АЖ, АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

2.1 Сайхан сумын бүтээн байгуулалтын ажилд 20,000,000 /хорин сая/ төгрөгтэй дүйцэх хэмжээний ажил үйлчилгээ үзүүлнэ.

2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн газарт амьдарч байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах

2.3 Орон нутгийн 5-10 иргэнийг ажлын байраар хангах

2.4 Сайхан сумын байгаль орчны улсын хяналтын байцаагчид сар бүр тухайн орд газрынхаа нөөц болон олборлолт явуулсан мэдээ тайланг хүргүүлж байх

2.5 Эвдрэлд орсон газрын байгаль орчныг нөхөн сэргээх, мод, бут, сөөг, олон наст ургамал тарих

ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Сумын нутаг дэвсгэр дээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

3.2 Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д үндсэн үйлдвэрлэлээс гадна бусад ажил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.

3.3 Сумаас уурхайн үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл солилцоно.

ДӨРӨВ. ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛҮҮД

4.1 Суманд хэрэгжих томоохон төсөл /орон сууц, зам гүүр, дэд бүтэц/ гэм мэт хэрэгжүүлэхэд хамтран оролцох

Зураг 15. Нийгмийн хариуцлагын гэрээ

- 4.2 Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах
4.3 Уул уурхайн сургалт дадлага хийхэд хамтран ажиллана.

ТАВ. БУСАД БОЛОН ХАРИУЦЛАГА

5.1 Хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй улсын байцаагчийн тавьсан шаардлагыг үл хүндэтгэсэн тохиолдолд ААНБ-ын тусгай зөвшөөрлийг холбогдох газарт уламжилж цуцлах хүртэл арга хэмжээ авах болно.

5.2 Энэхүү гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаагаар байгуулав.

5.3 Дээрх гэрээг жил бүр тогтмол дүгнэж байх бөгөөд гэрээний аль нэг тал үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн нь гэрээг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Сайхан сумын Засаг даргын Тамгын газрыг төлөөлж:

“Монкварц” ХК-ийг төлөөлж:

Сайхан сумын Засаг дарга

Захирал

Батмөнх овогтой Мөнхтөр

Утас:

8804 9904

Утас:

99119557

Зураг 16. Нийгмийн хариуцлагын гэрээ

ХААН БАНК		БАНК ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ / CLEARING SLIP	
Хүлээн авагчийн / Receiver's information Дугаар / No: 00130955400 Нэр / Name: С.Сайхан 381Тээр Х.С МНТ: ₮5,000,000.00M *Таван сая төгрөг*		Хүлээн авагчийн / Receiver's information Дугаар / No: 5030346141 Нэр / Name: МОНКВАРЦ МНТ: ₮5,000,000.00M *Таван сая төгрөг*	
Хүлээн авагчийн / Receiver's information Дугаар / No: 5030346141 Нэр / Name: МОНКВАРЦ МНТ: ₮5,000,000.00M *Таван сая төгрөг*		Хүлээн авагчийн / Receiver's information Дугаар / No: 5030346141 Нэр / Name: МОНКВАРЦ МНТ: ₮5,000,000.00M *Таван сая төгрөг*	

Зураг 17. Нийгмийн хариуцлагын гэрээний төлбөрийн баримт

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд уурхай болон бутлан ангилах үйлдвэр, ажилчдын тосгон орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.



2025-04-25

Нэг. Гэрээний зорилго

- 1.1. Үйлдвэр, албан байгууллага, аж ахуйн нэгжийн болон хувийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчинд гарч болох хими, физик, биологийн хувьсал өөрчлөлт, агвар, усан мандал, хөрсний бохирдолтын түвшинд байгаль орчны ажиглалт, судалгаа, хяналт шинжилгээ хийж, дүгнэлт өгөх.
- 1.2 Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2, 3,-р заалт, 11-р зүйлийн 2-р заалтуудыг аж ахуйн нэгж дээр хэрэгжүүлэн биелүүлэхэд оршино.
- 1.3 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй тухайн аж ахуйн нэгжийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлыг гүйцэтгэх.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх ажлыг Аймгийн УЦУОШТөвийг төлөөлж БОШЛабораторийн эрхлэгч М.Аягүл нөгөө талаас “Мон кварц” ХХК-нийг төлөөлж гүйцэтгэх захирал Г. Мягмарсүрэн нар хариуцан энэхүү гэрээг хийв.

Гурав. Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн хүлээх үүрэг.

- 3.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан ба ерөнхий үнэлгээнд заасан хөтөлбөр ажлын дагуу Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа “Мон кварц” ХХК-ны ил уурхайгаас 5-р сард агаар, ус, хөрсний дээжийг байгаль орчны лабораториос очиж дээж аван гэрээнд заагдсан элементийг, стандартын дагуу шинжилгээ хийж, дүгнэлтийг хугацаанд нь гаргаж өгнө.
- 3.2 Байгаль орчны хяналт шинжилгээ хийх багаж төхөөрөмж, шаардагдах урвалж бодис, материалаар ханган ажиллах.
- 3.3. Байгаль орчны хяналт шинжилгээний дүн мэдээлэл, дүгнэлтийг тухай бүр нь хариуцагч байгууллагад гаргаж өгөх
- 3.4. Хийсэн шинжилгээний нэхэмжлэлийг шинжилгээний дүнгийн хамт хүргүүлэх бөгөөд уг нэхэмжлэлийн дагуу 14 хоногийн дотор төлсөн байх. Мөнгө төлөөгүй хоног тутамд 0.5%-р алданги тооцно.

Дөрөв. “Мон кварц” ХХК-ны хүлээх үүрэг

- 4.1 Шинжилгээний дүн шинжээчийн дүгнэлтээр илэрсэн зөрчил шаардлагыг тухай бүр нь арилгаж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх.
- 4.2 Байгаль орчны хяналт шинжилгээ хийж гүйцэтгэсэн ажлын үнэлгээг байгаль орчны яамнаас тогтоосон тарифт үнэлгээний дагуу 178000 төгрөгийг Сэлэнгэ аймаг УЦУОШТөвийн Төрийн сангийн MN530090100130013015 тоот дансанд шилжүүлэн тооцоо хийж дуусгасан байх.

Зураг 18. ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэх тухай гэрээ

Тав. Хамтран хүлээх үүрэг

- 5.1 Хоёр тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар нэг нэгэндээ харилцан шаардлага тавина.
- 5.2 Гэрээ нь байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан ба ерөнхий үнэлгээ хүчин төгөлдөр байх хугацаанд мөрдөгдөж байх болно.
- 5.3 Гэрээний талаар маргаантай асуудал гарвал аль болох хэлэлцэн тохирох бодлого баримтлах бөгөөд харилцан, тохирч, шийдвэрлэж чадахгүй бол төрийн дээд шатны байгууллагад хандана.
- 5.4 Байгаль орчны төлөв байдлын гэрээний дагуу хийгдсэн ажлыг 2025 оны 12-р сарын 25-нд харилцан дүгнэж тайланг дарга, захиралуудад танилцуулах

УЦУОШТөвийн
БОШЛ-ерөнхий инженер
/М.Аягүл/

Утас: 70363983
96862233

Талуудын төлөөлөгчид:

"Мон кварц" ХХК-ны
гүйцэтгэх захирал
/Г.Мягмарсүрэн/

Утас: 99119557

Хавсралт 1

"Мон кварц" ХХК-тай хийгдэх Байгаль орчны шинжилгээ хийх төлөвлөгөө

Шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Шинжилгээ хийх сар
	VIII
Агаарын шинжилгээ	Агаарын зүхэрлэг хий, азотын давхар исал, нийт тоос /үнэ 44500*1=44500/
Усны шинжилгээ	Ундны ус 1*65000=65000
Хөрс	Агрохими /үнэ 68500*1=68500/
Нийт дүн	178000

Хавсралт баталгаажуулсан:

УЦУОШТөвийн
БОШЛ-ерөнхий инженер
/М.Аягүл/

Утас: 70363983
96862233

"Мон кварц" ХХК-ны
гүйцэтгэх захирал
/Г.Мягмарсүрэн/

Утас: 99119557

Зураг 19. ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэх тухай гэрээ

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 /A21

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

“Мон кварц” ХХК

Сайхан сум

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

1, Агаарын дээж

2025 - 04-29

Сорилтын арга, аргачлал MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021, MNS4048-88

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт

хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос

Шинжилгээ хийж дууссан огноо

2025 – 04 - 30

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/м3				
		Азотын давхар исэл (NO ₂)	Хүхэрлэг хий (SO ₂)	Тоос (нийт)		
				Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
1	Уурхай	0.010	0.003	0.056	0.029	0.115
	MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж	0.200	0.450	0.500		

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах “Мон кварц” ХХК-ний орчмоос авсан агаарт азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоос MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер
Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн эрхлэгч



С.Цэнджав
М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 20. Агаарын чанарын шинжилгээний үзүүлэлт

Агаарын чанарын шинжилгээний үзүүлэлтээс харахад MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол илрээгүй байна.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / X14

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

Шинжилгээний аргын стандарт

Шинжилгээ хийж дууссан огноо

“Мон кварц” ХХК

Сайхан сум

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

1, Хөрс

2025 - 04- 29

агрохимийн үзүүлэлт

MNS 3310:1991

2025 – 05 -05

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд, мг/кг							
		РН	Сульфат	Чийг %	Нитрат	Аммоний азот	Ялзмаг	ЕС, μS/cm	Фосфор
1	Нөлөөлөлд өртөөгүй	9.37	150.0	1.01	8.7	17.2	1.5	38.4	10.56
	MNS 3297:2019 стандарт дахь ЗДХ	6-9	160.0	-	130.0	-	-		

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах “Мон кварц” ХХК-ний орчмоос авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 3297:2019 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хөрсний орчин 1.04 дахин их байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер
Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн эрхлэгч



С.Цэнджав
М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 21. Хөрсний шинжилгээний үр дүн

Хөрсний шинжилгээний дүнгээр хөрсөн дахь сульфат, нитратын агууламж MNS3297:2019 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн хэмжээнд байна.

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж,
2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036- 3983



БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2025 / № У46

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас

Дээжийн тодорхойлолт

Дээж авсан хүний нэр, албан тушаал

Дээжийн тоо, төрөл

Хүлээн авсан огноо

Дээжийн тодорхойлох үзүүлэлт

Шинжилгээ хийж дууссан огноо

“Мон кварц” ХХК

Сайхан сум

БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

1, Ундны ус

2025 – 04 -29

гол ион, биогений элемент

2025 – 05 - 01

Үр дүн:

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Шугамын ус	MNS 900:2018
MNS ISO 10523:2001	РН –орчин	8.11	6.5-8.5
MNS 1097:2023	Өнгө		20 градус
MNS 1097:2023	Кальци	42.6	100.0
MNS 1097:2023	Магни	42.5	30.0
MNS 1097:2023	Аммоны азот	0.09	1.5
MNS 4430:2005	Темпер /нийт/	0.07	0.3
MNS ISO 9297:2005	Хлор	21.2	350.0
MNS 6271:2011	Сульфат	146.7	500.0
MNS 6779:2019	Нитрит	0.008	1.0
MNS 6834:2020	Нитрат	4.12	50.0
MNS 6831:2020	Гидрокарбонат	284.3	
MNS ISO6059:2005	Хатуулаг	5.62	7.0
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар	1.6	
MNS 6272:2011	Фтор	0.92	0.7-1.5
MNS 1097:2023	Эрдэсжилт	589.6	
MNS 1097:2023	Na+K	62.0	
MNS ISO 6878:2001	Фосфор	0.081	3.5
MNS ISO 7888:1999	ЕС, µs/cm	892.0	1000.0
	Булингар	0.96	5.0
MNS 6835:2020	Цахиур	5.55	
MNS ISO 11083:2001	Хром+6	Илрээгүй	

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах “Мон кварц” ХХК-ний ундны усанд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS900:2018 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс магнийн хэмжээ 1.42 дахин их байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-н инженер

Шинжилгээг хянасан: БОШЛ-эрхлэгч



М.Өнөржаргал

М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 22. Усны шинжилгээний үр дүн

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан
БОУАӨЯ-ны цахим системд илгээсэн болно.

ДҮГНЭЛТ

Манай компани нь 2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан. Түүнчлэн уурхайн
эвдрэлтэй замд хайрган хучилт хийж засварласан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан
сумын ЗДТГ-тай хамтран ажилласан.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
Түүнчлэн хог хаягдлыг түр хадгалах цэгийг байгуулсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж
ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанар, дуу
чимээний хэмжилт хийлгэж, хөрс, усны шинжилгээ авч лабораторид
шинжлүүлсэн.
- ✓ Ус ашиглах гэрээг байгуулж, гэрээний дагуу ажилласан.
- ✓ Өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн
бөгөөд тэсрэх бодисын сав баглаа боодлыг гэрээт байгууллагад буцаан өгч
аюул осолгүй ажилласан.
- ✓ Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, хамтран
ажилласан.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг
цаг тухайд нь 100 хувь хийж гүйцэтгэсэн болно.